

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бага, дунд боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)

2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 803 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн сургууль байна. (Зураг 1)

Зураг 1. 2018-2019 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуулийн тоо (өмчийн хэлбэр, ангиллаар)



Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо (өмчийн хэлбэр, ангиллаар)

	Ерөнхий боловсролын сургууль							
	Бүгд	төрийн	хувийн	Бүгд	бага	дунд	ахлах	цогцолбор
2014-2015	762	628	134	762	62	136	514	50
2015-2016	768	636	132	768	62	118	538	50
2016-2017	778	645	133	778	69	117	542	50
2017-2018	798	652	146	798	74	116	562	46
2018-2019	803	656	147	803	80	115	563	45

2018-2019 оны хичээлийн жилд нийт сургуулийн 80 буюу 10.0 хувь нь бага сургууль, 115 буюу 14.3 хувь нь дунд сургууль, 563 буюу 70.1 хувь нь ахлах сургууль, 45 буюу 5.6 хувь нь цогцолбор сургуулийн ангилалд багтаж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад бага сургуулийн тоо 6-аар, ахлах сургуулийн тоо 1-ээр өссөн бол, дунд сургуулийн тоо 1-ээр, цогцолбор сургуулийн тоо 1-ээр тус тус буурсан байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 55 (8.4%) нь бага сургуулийн, 115 (17.5%) нь дунд сургуулийн, 446 (68.0%) нь ахлах сургууль, 40 (6.1%) нь цогцолбор сургуулийн;

Хувийн сургуулийн 25 (17.0%) нь бага сургуулийн, 117 (79.6%) нь ахлах сургуулийн, 5 (3.4%) нь цогцолбор сургуулийн ангилалд тус тус багтаж сургалтын ажил эрхэлж байна.

Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургууль (байршил, хэв шинжээр)

	Ерөнхий боловсролын сургууль								
	Бүгд	хот	хөдөө	Бүгд	ердийн	мэргэжлийн	гүнзгий рүүлсэн	тусгай	олон улсын хөтөлбөр
2014-2015	762	214	548	762	633	14	100	6	9
2015-2016	768	215	553	768	662	14	81	6	5
2016-2017	778	226	552	778	684	15	66	6	7
2017-2018	798	241	557	798	705	16	63	6	8
2018-2019	803	245	558	803	708	15	67	6	7

Нийт сургуулийн 69.5 хувь буюу 558 нь хөдөөд, 30.5 хувь буюу 245 нь нийслэлд сургалтын ажил эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 708 буюу 88.2 хувь нь ердийн, 15 буюу 1.9 хувь нь мэргэжлийн, 67 буюу 8.3 хувь нь гүнзгийрүүлсэн, 6 буюу 0.7 хувь нь тусгай, 7 буюу 0.9 хувь нь олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Өмнөх жилээс ердийн болон гүнзгийрүүлсэн сургуулийн тоо өссөн бол мэргэжлийн болон олон улсын хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулийн тоо буурсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, бүлэг дүүргэлт (өдрийн анги)

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 20.5 мянган бүлэг хичээллэж байна. Нийт бүлгийн 18.5 мянга буюу 89.9 хувь нь төрийн өмчийн, 2.0 мянга буюу 10.1 хувь нь хувийн сургуульд ногдож байгаа бөгөөд нийт бүлгийн 51.1 хувийг бага, 32.8 хувийг дунд, 16.1 хувийг ахлах ангийн бүлэг тус тус бүрдүүлж байна. Бүлгийн тоо өнгөрсөн хичээлийн жилээс 2.6 хувь (үүнээс бага анги 4.3, дунд анги 6.2 хувиар өссөн бол, ахлах анги 7.8 хувиар буурсан)-иар өссөн (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг (өдрийн анги, ээлж, тоогоор)

	Бүлгийн тоо							
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж
2014-2015	18,521	9,132	5,739	3,650	18,521	11,734	6,630	157
2015-2016	19,304	9,554	5,429	4,321	19,304	12,058	7,071	175
2016-2017	19,677	9,795	6,171	3,711	19,677	12,215	7,238	224
2017-2018	20,211	10,214	6,553	3,444	20,211	12,705	7,320	186
2018-2019	20,574	10,518	6,746	3,310	20,574	13,240	7,122	212

Ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлгийн 64.4 хувь нь нэгдүгээр ээлжинд, 34.6 хувь нь хоёрдугаар ээлжинд, 1.0 хувь нь гуравдугаар ээлжинд хичээллэж байна.

Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжинд хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)

	Бүлгийн тоо				Хүүхдийн тоо			
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2014-2015	157	157	-	-	5,469	5,469	-	-
2015-2016	175	175	-	-	6,311	6,311	-	-
2016-2017	224	218	6	-	8,755	8,566	189	-
2017-2018	186	159	27	-	7,335	6,412	923	-
2018-2019	212	181	25	6	8,451	7,511	786	154

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд 28 сургуулийн 212 бүлэгт 8,451 суралцагч 3 ээлжээр хичээллэж байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 85.4 хувь нь бага ангийн, 11.8 хувь нь дунд ангийн, 2.8 хувь нь ахлах ангийн бүлэг байна.

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжинд хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)

Он		2014-2015 он			2015-2016 он			2016-2017 он			2017-2018 он			2018-2019 он		
Үзүүлэлт	Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		
		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө	
Сургуулийн тоо		22	21	1	24	23	1	32	31	1	25	22	3	28	23	5
III ээлж	Бүлэг	157	151	6	175	174	1	224	222	2	186	173	13	212	188	24
	Хүүхдийн тоо	5,469	5,263	206	6,311	6,278	3	8,755	8,706	49	7,335	6,932	403	8,451	7,743	708

3 ээлжээр хичээллэж байгаа 28 сургуулийн 5 нь хөдөө аймагт, 23 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт 28.8 байгаа нь өмнөх жилээс 0.5 пунктээр, үүнээс төрийн өмчийн сургуульд 29.9 байгаа нь өмнөх жилээс 0.4 пунктээр, хувийн сургуульд 17.8 байгаа нь өмнөх жилээс 1.2 пунктээр тус тус өссөн байна.

Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс их буюу 38.0-54.4-тэй нэр бүхий нийслэлийн 35, аймгийн 3 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 6. Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс их ерөнхий боловсролын сургуулийн бүлэг дүүргэлт (Сүүлийн хоёр жилээр)

№	Аймаг, нийслэл, дүүрэг	Сургуулийн нэр	2017-2018 он	2018-2019 он	
1	Улаанбаатар	Чингэлтэй дүүрэг	23-р сургууль	53.7	54.4 ↑
2			5-р сургууль	46.3	46.2 ↓
3			24-р сургууль	42.3	42.9 ↑
4			50-р сургууль	38.4	38.4 -
6		Сүхбаатар дүүрэг	1-р сургууль	50.7	53.9 ↑
7			3-р сургууль	45.0	47.3 ↑
8			31-р сургууль	41.6	42.6 ↑
9			2-р сургууль	39.6	41.5 ↑
10			45-р сургууль	37.9	38.4 ↑
11			58-р сургууль	37.4	38.0 ↑
12		Хан-уул дүүрэг	18-р сургууль	50.3	50.8 ↑
13			52-р сургууль	46.4	45.2 ↓
14			Буянт-ухаа цогцолбор сургууль	41.5	42.9 ↑
15			118-р сургууль	37.2	39.2 ↑
16		Баянзүрх дүүрэг	84-р сургууль	46.3	46.7 ↑
17			33-р сургууль	43.5	44.6 ↑
18			44-р сургууль	40.3	41.3 ↑
19			111-р сургууль	39.7	42.9 ↑
20			14-р сургууль	37.7	41.8 ↑
21			48-р сургууль	37.0	46.7 ↑
22			53-р сургууль	-	38.1 ↑
23			Шавь цогцолбор	-	39.1 ↑
24			133-р сургууль	-	41.2 ↑

25		Баянгол дүүрэг	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	42.4	42.7 ↑
26			20-р сургууль	42.4	42.3 ↓
27			93-р сургууль	41.8	42.5 ↑
28			Оюуны-ундраа цогцолбор сургууль	37.7	39.9 ↑
29			38-р сургууль	-	42.7 ↑
30		Сонгинохайрхан дүүрэг	12-р сургууль	41.9	44.6 ↑
31			104-р сургууль	39.6	39.1 ↓
32			122-р сургууль	39.1	42.2 ↑
33			62-р сургууль	39.0	40.7 ↑
34			Ирээдүй цогцолбор сургууль	38.7	39.1 ↑
35			42-р сургууль	37.0	37.4 ↑
36	Дархан-уул аймаг		Оюуны ирээдүй цогцолбор	38.4	39.2 ↑
37	Орхон аймаг		5-р сургууль	38.3	38.3 -
38	Өвөрхангай		Арвайхээр-1	-	38.0 ↑

Өмнөх жилээс 4 сургуулийн бүлэг дүүргэлт буурсан, 2 сургууль хэвээр байгаа бол бусад бүх сургуулийн бүлэг дүүргэлт өссөн байна. Энэ нь шинээр элсэгч 4.0 мянгаар, нийт суралцагч 20.0 мянгаар нэмэгдсэнтэй холбоотой юм.

Суралцагчид

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 600.4 мянган (өдрөөр 593,150, оройгоор 108, эчнээгээр 219, дүйцсэн хөтөлбөрөөр 6,917) суралцагч өдөр, орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байна. Насан туршийн боловсролын төвд 9,917 хүүхэд дүйцсэн хэлбэрээр суралцаж байна. Суралцагчдын тоо өнгөрсөн хичээлийн жилээс 19,234-өөр, үүнээс өдрөөр суралцагч 20,398-аар тус тус өссөн бол, эчнээгээр суралцагч 131-ээр, оройгоор суралцагч 3-аар, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 1,030-аар тус тус буурсан байна. (Зураг 2)

Зураг 2. 2018-2019 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид (сургалтын хэлбэрээр)



Хүснэгт 7. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид (сургалтын хэлбэрээр)

	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид				
	Нийт	өдөр	орой	эчнээ	дүйцсэн
2014-2015	517,878	506,816	315	680	10,067
2015-2016	546,215	535,055	244	723	10,193
2016-2017	561,693	551,953	177	447	9,116
2017-2018	581,160	572,752	111	350	7,947
2018-2019	600,384	593,150	108	219	6,917

Өдрөөр суралцагчдын 93.3 хувь нь төрийн өмчийн сургуульд, 6.7 хувь нь хувийн сургуульд суралцаж байна (Хүснэгт 8). Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бага ангийн суралцагчдын тоо 5.7, дунд анги 4.4 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн суралцагчдын тоо 5.8 хувиар буурсан байна.

Зураг 3. 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (өмчийн хэлбэрээр)




Хүснэгт 8. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (анги, өмчийн хэлбэрээр)

	Суралцагчдын тоо						
	Бүгд	Төрийн	Хувийн	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2014-2015	505,816	476,676	29,140	505,816	251,204	158,634	95,978
2015-2016	535,055	504,070	30,985	535,055	271,687	147,031	116,337
2016-2017	551,953	520,201	31,752	551,953	288,345	167,364	96,244
2017-2018	572,752	537,740	35,012	572,752	309,355	176,210	87,187
2018-2019	593,150	553,562	39,588	593,150	327,019	184,017	82,114

Суралцагчдын 60.3 хувь буюу 358.8 мянга нь нэгдүгээр ээлжинд, 38.1 хувь буюу 225.9 мянга нь хоёрдугаар ээлжинд, 1.4 хувь буюу 8.4 мянга нь гуравдугаар ээлжинд хичээллэж байна. Гуравдугаар ээлжинд хичээллэж байгаа хүүхдийн тоо өмнөх оноос 15.2 пунктээр өссөн байна.

Зураг 4. 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцагчид (ээлжээр)



Суралцагчдын хүйсийн харьцаа

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 49.8 хувийг охид, 50.2 хувийг хөвгүүд бүрдүүлж байгаа нь өмнөх оноос охидын эзлэх хувь 0.1 пунктээр буурсан бол хөвгүүдийн эзлэх хувь эсрэгээрээ өссөн байна. Энэ харьцаа төрийн өмчийн сургуульд 49.9:50.1, хувийн сургуульд 48.8:51.2-тай байна. Бага ангийн нийт суралцагчдын 48.9 хувь, дунд ангийн 49.7 хувь, ахлах ангийн 53.7 хувийг охид эзэлж байна. (Хүснэгт 9). Хүйсийн ялгааны индекс 1.0 байна. Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй сурагч ногдож байна гэсэн үг. Ахлах ангид суралцагчдын хүйсийн ялгаа ихэсч байгаа бол бага ангид энэхүү харьцаа өмнөх жилтэй ижил, дунд ангид эмэгтэй суралцагчдын эзэх хувь 0.1 пунктээр өссөн байна.

Хүснэгт 9. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид хүйсээр (ангиар)

Үзүүлэлт	бага		дунд		ахлах	
	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
2014-2015	49.0%	51.0%	49.3%	50.7%	54.4%	45.6%
2015-2016	49.0%	51.0%	49.3%	50.7%	54.8%	45.2%
2016-2017	49.0%	51.0%	49.7%	50.3%	54.6%	45.4%
2017-2018	48.9%	51.1%	49.6%	50.4%	54.3%	45.7%
2018-2019	48.9%	51.1%	49.7%	50.3%	53.7%	46.3%

Суралцагчдын насны ангилал


Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 55.0 хувийг 6-10 настай суралцагч буюу бага боловсрол эзэмших насны суралцагчид, 30.3 хувийг 11-14 настай, 14.3 хувийг 15-17 настай, 0.4 хувийг 18 ба түүнээс дээш настай суралцагч бүрдүүлж байна. Сургуулийн эрт элсэлт бүртгэгдээгүй, 15-17 настай суралцагчид 2.1, 18 ба түүнээс дээш настай суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол 6-10 настай суралцагчдын тоо 1.2, 11-14 настай суралцагчид 1.1 пунктээр тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (насаар)

Он	Суралцагчдын тоо						
	Бүгд	5 хүртэлх нас	6 нас	7-10 нас	11-14 нас	15-17 нас	18 ба түүнээс дээш
2014-2015	505,816	3,430	58,828	183,452	170,330	87,535	2,241
2015-2016	535,055	2,490	63,449	202,444	163,387	97,996	5,289
2016-2017	551,953	1,672	59,082	225,638	164,260	97,724	3,577
2017-2018	572,752	383	65,359	242,577	167,279	94,179	2,975
2018-2019	593,150	-	69,139	257,257	179,474	85,085	2,195

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6,518 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдүүд нь нийт суралцагчдын 1.1 хувийг эзэлж байна.

Зураг 5. 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



Хүснэгт 11. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
2014-2015	11,072	4,104	1,214	1,560	1,185	1,796	1,213
2015-2016	9,143	3,086	1,053	1,387	766	1,374	1,477
2016-2017	8,362	2,632	951	1,286	881	1,252	1,360
2017-2018	7,279	2,102	828	1,136	788	1,091	1,334
2018-2019	6,518	1,638	712	958	931	956	1,323

Нэгдүгээр ангид шинээр элсэгч

2018-2019 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид суралцагчдын 99.6 хувь (67,974)-ийг шинээр элссэн суралцагч бүрдүүлж байгаа нь өмнөх онтой ижил түвшинд байна. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 6.3 хувиар өссөн бөгөөд суралцагчдын 93.3 хувь нь төрийн өмчийн, 6.7 хувь нь хувийн сургуульд элсжээ. (Зураг 6)

Зураг 6. 2018-2019 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид



Хүснэгт 12. Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид (өмчийн хэлбэрээр)

Хичээлийн жил	Шинээр элсэгч	Үүнээс		Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан	Шинээр элсэгчдээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Нийт элсэгчдээс шинээр элсэгчдийн эзлэх хувь
		Төрийн өмчийн сургуульд	Хувийн сургуульд			
2014-2015	60,205	56,613	3,592	51,679	85.8	96.5
2015-2016	65,197	61,556	3,641	43,132	66.2	98.7
2016-2017	62,000	58,687	3,313	42,315	68.3	99.6
2017-2018	67,974	64,148	3,826	43,932	64.6	99.6
2018-2019	72,247	67,385	4,862	50,932	70.5	99.6

Элсэгчдийн 94.1 хувийг 6 настай суралцагчид буюу өмнөх оноос 1.2 пунктээр өссөн байна.

Нийт элсэгчдийн 70.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бөгөөд өмнөх оноос 5.9 пунктээр өссөн бол элсэгчдийн 29.5 хувь нь сургуульд элсэхийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.

Ажиллагчид болон багшлах боловсон хүчин

Ерөнхий боловсролын сургуульд 49,4 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 90.7 хувь нь төрийн өмчийн сургуульд, 9.3 хувь нь хувийн сургуульд ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 3.0 хувь буюу 1,450 (төрийн өмчийн сургууль 1,091-ээр, хувийн сургууль 359)-аар нэмэгдсэн. (Зураг 7)

Зураг 7. 2018-2019 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид




Хүснэгт 13. Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Үүнээс		Төрийн өмч	
		Төрийн өмч	Хувийн өмч	Хот	Хөдөө
2014-2015	45,881	41,951	3,930	12,114	29,837
2015-2016	46,791	42,936	3,855	12,645	30,291
2016-2017	47,168	43,261	3,907	13,246	30,015
2017-2018	47,991	43,754	4,237	13,263	30,491
2018-2019	49,441	44,845	4,596	14,142	30,703

Ерөнхий боловсролын сургуульд 30,4 мянган багш ажиллаж байгаагийн 90.8 хувь нь төрийн өмчийн сургуульд, 9.2 хувь нь хувийн сургуульд ногдож байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 4.0 хувь буюу 1,169 (төрийн өмчийн сургууль 873-аар, хувийн сургууль 296)–аар нэмэгдсэн. Нийт багш нарын 24,879 буюу 81.8 хувь нь эмэгтэй, 18.2 хувь нь эрэгтэй бол, 35.3 хувь буюу 10.7 мянга нь бага анги, 64.7 хувь буюу 19.7 мянга нь дунд, ахлах ангийн багш байна. (Зураг 8)

Зураг 8. 2018-2019 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш



Хүснэгт 14. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш

	Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш				Нийт	Төрийн	Хувийн
	Нийт	бага	дунд	ахлах			
2014-2015	27,449	8,901	11,233	7,315	27,449	25,218	2,231
2015-2016	28,490	9,877	11,454	7,159	28,490	26,209	2,281
2016-2017	28,889	9,976	11,708	7,205	28,889	26,527	2,362
2017-2018	29,242	10,238	11,960	7,044	29,242	26,742	2,500
2018-2019	30,411	10,736	12,670	7,005	30,411	27,615	2,796

Багш нарын боловсролын түвшин, насны ангилал, ажилласан жил


Нийт багш нарын 0.1 хувийг докторын зэрэгтэй, 14.3 хувийг магистрын зэрэгтэй, 73.3 хувийг бакалавр, 9.5 хувийг дипломын боловсролтой багш эзэлж байна. (Хүснэгт 15). Өмнөх жилээс докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь хэвээр, магистрийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.5 пунктээр, бакалаврын зэрэгтэй багш 0.9 пунктээр тус тус өссөн бол дипломын боловсролтой багшийн эзлэх хувь 1.2 пунктээр буурсан байна.

Зураг 9. 2018-2019 оны хичээлд ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Мэргэжлийн зэрэг, боловсролын түвшин



Ажилласан жил



Хүснэгт 15. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн эзлэх хувь ¹	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2014-2015	99.8	23	3,670	19,441	4,263	52
2015-2016	98.9	22	4,085	20,142	3,916	325
2016-2017	98.6	23	3,983	20,949	3,530	404
2017-2018	97.0	23	4,034	21,185	3,131	869
2018-2019	97.2	19	4,347	22,301	2,901	843

Багш нарын 28.3 хувь нь 30 хүртэл насны, 35.3 хувь нь 30-39 насны, 24.1 хувь нь 40-49 насны, 11.4 хувь нь 50-59 насны, 0.9 0.7 хувь 60 ба түүнээс дээш насны багш нар байна. (Хүснэгт 16). 40-49 насны багшийн эзлэх хувь 0.8 пунктээр, 60 ба түүнээс дээш насны багшийн эзлэх хувь 0.2 пунктээр өссөн бол 30 хүртэл насны багшийн эзлэх хувь 0.2, 30-39 насны багшийн эзлэх хувь 0.7, 50-59 насны багшийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 16. Багш нарын нас (насны ангилалаар)

	30 хүртэл	30-39	40-49	50-59	60 ба түүнээс дээш
2014-2015	8,222	10,011	5,688	3,369	159
2015-2016	8,469	10,277	6,056	3,515	173
2016-2017	8,378	10,406	6,520	3,389	196
2017-2018	8,331	10,526	6,807	3,365	213
2018-2019	8,606	10,741	7,317	3,462	285

¹ Мэргэжлийн багшийн эзлэх хувь -Дипломоос дээш боловсролтой багшийн хувь

Багш нарын ажилласан жил буюу ажлын туршлагыг авч үзэхэд нийт багш нарын 6.0 хувь нь анхны жилдээ, 31.8 хувь нь 1-5 жил, 18.9 хувь нь 6-10 жил, 15.9 хувь нь 11-15 жил, 10.1 хувь нь 16-20, 5.1 хувь нь 21-25, 11.3 хувь нь 25-аас дээш жил ажиллаж байна. (Хүснэгт 17).

Өмнөх жилээс анхны жилдээ ажиллаж байгаа багшийн эзлэх хувь 0.1, 1-5 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 0.8, 11-15 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 0.3, 21-25 жил ажиллаж байгаа багшийн эзлэх хувь 0.2, 16-20 жил ажилласан багшийн эзлэх хувь 0.2 пунктээр тус тус өссөн бол, 6-10 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 1.2, 25-аас дээш ажиллаж буй багшийн эзлэх хувь 0.4 пунктээр буурсан байна.

Нийт багшийн 57.6 хувь нь 10 хүртэлх жил ажилласан багш нар байна.

Хүснэгт 17. Багш нарын ажлын туршлага (ажилласан жилээр)

	Ажилласан жил						
	Анхны жилдээ	1-5 жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	25-аас дээш жил
2014-2015	611	8,196	6,974	4,158	2,465	1,979	3,066
2015-2016	2,110	8,869	5,740	4,785	2,321	1,396	3,269
2016-2017	1,675	9,405	5,892	4,348	2,669	1,420	3,480
2017-2018	1,732	9,287	5,866	4,576	2,900	1,446	3,435
2018-2019	1,838	9,919	5,752	4,825	3,082	1,562	3,433

Багш нарын 51.0 хувь нь мэргэшлийн зэрэгтэй тэдгээрийн 0.9 хувийг зөвлөх, 29.1 хувийг тэргүүлэх, 70.0 хувийг заах аргач зэрэгтэй багш бүрдүүлж байна. Өмнөх жилээс зэрэгтэй багшийн эзлэх хувь 10.6 пунктээр өссөн бол, зөвлөх зэрэгтэй багшийн эзлэх хувь хэвэндээ, тэргүүлэх зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.4 пунктээр буурсан бол, заах аргач зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.4 пунктээр буурсан байна.